



ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 4-р сарын 25-ны өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороонд байрлах Хаан Банкны Сөүл оффисын Хаан театрт боллоо. Хурлыг Говь ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Гэрэлмаа даргалж, ТУЗ-ийн хараат бус гишүүн А.Жаргалмаа, ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Хүрэлбаатар, Гүйцэтгэх захирал Б.Амарсайхан ба Гүйцэтгэх удирдлагын ба, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ болон Кэй Пи Эм Жи Аудит ХХК-ийн Туслах менежер аудитор Д.Чинболд нар оролцов.

ХУРЛЫН НЭЭЛТ

Хөтлөгч: Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, зочид төлөөлөгчид өө. “Говь” ХК-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхлэхэд хэдхэн хором үлдлээ. Та бүхнийг суудлаа эзлэн, гар утас, төхөөрөмжөө дуугүй горимд тохируулахыг хүсье. Хурлын ирц бүрдсэн тухай албан ёсоор мэдэгдэнэ үү хэмээн Тооллогын комиссын дарга Хатагтай Сайнзулыг урьж байна..

1. ХУРЛЫН ИРЦИЙГ ТАНИЛЦУУЛАХ

Тооллогын комиссын дарга Н.Сайнзул танилцуулав.

Тооллогын комиссын дарга Н.Сайнзул бүртгэлийн өдөр 2025 оны 4-р сарын 4-ний өдөр байсныг дурдаж, бүртгэлийн өдөр Говь ХК-ийн нийт саналын эрхтэй хувьцааны тоо 780,112,500 байгаагаас хурлын материалтай урьдчилан танилцан санал өгөх арга хэлбэрээр 13,341,856 буюу 1.71% саналын эрхтэй 563 хувьцаа эзэмшигч, 4-р сарын 25-ны өдрийн хуралд биечлэн оролцох арга хэлбэрээр 681,455,412 буюу 87.35% саналын эрхтэй 99 хувьцаа эзэмшигч оролцсоноор нийт хурлын ирц 89.06% болсон тухай хурлын даргад мэдэгдэж, хурлын ирц бүрдэж Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтад заасан шаардлагыг хангасныг танилцуулав.

Хөтлөгч: Тооллогын комиссын даргадаа баярлалаа. Ийнхүү “Говь” Хувьцаат Компани нь 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа хуульд заасан хугацаа, журмын дагуу зарлан нээж байна.

Хурлын ирц бүрдсэн тул албан ёсоор нээж үг хэлнэ үү хэмээн Хурлын дарга, ТУЗ-ийн гишүүн Хатагтай Гэрэлмаа таныг урья.

2. ХУРЛЫН ДЭГИЙГ ТАНИЛЦУУЛАХ

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа танилцуулав.

Хурлын дарга Д.Гэрэлмаа: Энд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдэдээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Хурлын ирц хангалттай байгаа учир Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нээснийг мэдэгдье. Та бүхэнд тараан өгсөн хувьцаа эзэмшигчдийн хурлын эмхэтгэлд хурлын хөтөлбөрийг оруулсан байгаа. Хурал 14:00 цагт эхлэн, 16:00 цагт дуусахаар байгаа. Цагийн хуваарилалтыг дэлгэцээр харуулж байна. Энэ хурлаар бид 7 асуудалтай танилцана. Та бүхэндээ хэлэлцэх асуудлуудаа дарааллаар нь танилцуулъя:

1. Говь ХК-ийн 2024 оны санхүү үр дүн болон үйл ажиллагааны тайланг танилцуулах
2. 2024 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараахгүй тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах
3. ТУЗ-өөс компанийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг танилцуулах
4. Компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг танилцуулах
5. ТУЗ-ийн 2024 оны ажлын тайланг танилцуулах
6. ТУЗ-ийн 2025 оны цалингийн төсвийг танилцуулах
7. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулах

Хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье. Хүрэлцэн ирсэн та бүхэндээ баярлалаа.

Хөтлөгч: Одоо та бүхэнд Тооллогын комиссын бүрэлдэхүүнийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Хатагтай Сэлэнгэ танилцуулна.

3. ТООЛЛОГЫН КОМИССЫГ ТАНИЛЦУУЛАХ

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ танилцуулав.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ: Хүрэлцэн ирсэн хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. ТУЗ-ийн 2025 оны 3-р сарын 14-ний №04 тоот тогтоолоор энэ жилийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлах тухай шийдвэрийг гаргасан ба тус шийдвэрийн хавсралтаар Тооллогын комиссыг 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилсон байгаа. Та бүхэнд бүрэлдэхүүнийг танилцуулъя. Тооллогын комиссын даргаар Дотоод аудитын хэлтсийн ахлах аудитор Н.Сайнзул, нарийн бичгийн даргаар Аудитын менежер Д.Сарангуа, гишүүдээр Үйлдвэр бүртгэлийн албаны дарга Ц.Цэцэгбадам, Хүний нөөцийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Уянга, Аудитор Д.Сарангуа, Нягтлан бодогч Б.Ууганзаяа, Нягтлан бодогч Б.Урангоо гэсэн 6 хүний бүрэлдэхүүнтэй тооллогын комисс томилогдон ажиллаж байна. Тооллогын комиссын хувьд хурлын өнөөдрийн хурлын бүртгэлийг хийж, ирцийн албан ёсоор Хурлын даргад мэдэгдэх ба саналын хуудсаар авсан саналыг бүртгэж, хурлын үр дүнг нэгтгэн, тоолох үндсэн үүргийг хэрэгжүүлдэг байгаа. Эдгээр 6 гишүүн нь өнөөдрийн хэлэлцэж буй асуудалтай ямар нэгэн холбоогүй бөгөөд компанийн эрх бүхий албан тушаалтан биш байгаа гэдгийг албан ёсоор хэлмээр байна. Баярлалаа.

Хөтлөгч: Баярлалаа. Одоо хуралдааны дараагийн хэсэгт шилжиж хэлэлцэх асуудлуудтай танилцъя. Эхний хэлэлцэх асуудлын 1-р хэсэг болох "Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан"-гийн бичлэгийг хүлээн авч үзнэ үү.

4. ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫГ ТАНИЛЦУУЛАХ

4.1 Компанийн 2023 оны үйл ажиллагааны үр дүнг танилцуулах /1-р хэсэг/

/2024 оны үйл ажиллагааны үр дүнгийн талаарх 6 минутын видеог хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигч нарт дэлгэцээр үзүүлэв./

Хөтлөгч: Өмнөх оны хийсэн онцлох ажлуудтай дэлгэрэнгүй танилцаж чадсан гэж бодож байна. Ингээд 2-р хэсэг болох Компанийн 2024 оны санхүүгийн үр дүн болон 2025 оны төлөвлөгөөг танилцуулна уу хэмээн Гүйцэтгэх захирал Ноён Амарсайхан таныг индэр дээр урья.

4.1 Компанийн 2024 оны санхүү үр дүн болон 2025 оны зорилтыг танилцуулах /2-р хэсэг/

Гүйцэтгэх захирал Б.Амарсайхан танилцуулав.

Гүйцэтгэх захирал Б.Амарсайхан: Сайн байцгаана уу? Гүйцэтгэх захирал Амарсайхан миний бие та бүхэнд 2024 оны санхүүгийн үр дүн болон 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг танилцуулъя.

2024 онд саяны видео дээр гарсанчлан бид цөөнгүй ажлуудыг хийсэн ба тэр тусмаа онцлох 3 ажил энд харагдаж байна. Манай компанийн зүгээс гадаад болон дотоод зах зээл дээр борлуулалтыг хийх болон брэндийг үүсгэх гэдэг маш том зорилго болон зорилттой ажиллаж байна.

Үүний хүрээнд, нэгдүгээрт, брэндийн цогц шинэчлэлт буюу Rebranding хийсэн байгаа. Үр дүнд нь манай компанийн лого, симбол, уриа үг, лоозон, алсын хараа, эрхэм зорилго, сав баглаа болон харагдах байдал шинэчлэгдсэн байгаа. Бид зах зээлүүд дээрээ брэнд үүсгэх ажилтай уяж амжилттай эхлүүлсэн.

Хоёрдугаарт, Төв дэлгүүр буюу манай Flagship Store нь 2,200 м.кв талбайгаараа Монгол болон Дэлхийд номер 2-т ордог ноолуурын дэлгүүр байгаа. Үүндээ бид 2024 онд засвар хийн дотоод худалдан авагчид болон гадаад жуулчдыг худалдан авалт хийхэд нүүр бардам засвар, шинэчлэлтийг хийсэн.

Гуравдугаарт, бид систем хөгжүүлэлт буюу дижитал шилжилттэй холбоотой SAP ERP болон Үйлдвэрийн дамжлагын систем зэргийг амжилттай хэрэгжүүлж компанийн үйл ажиллагааг дараагийн түвшинд аваачиж чадсандаа баяртай байна.

Говь ХК-ийн 2024 оны санхүүгийн үр дүнг илүү дэлгэрэнгүй танилцуулъя.

2024 онд борлуулалтын төлөвлөгөө 98%-ийн гүйцэтгэлтэй буюу 247 тэрбумын борлуулалт хийсэн. Борлуулсан бүтээгдэхүүний гүйцэтгэл 97%-ийн гүйцэтгэлтэй буюу 1,055,000 ширхэг бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн борлуулсан. Цэвэр ашгийн хувьд 1.7 тэрбумын төлөвлөгөөтэй байсан боловч 3.7 тэрбумын алдагдалтай ажилласан. Алдагдалтай ажилласан 3 шалтгаан байгаа. Нэгдүгээрт, тухайн үедээ борлуулалтын төлөвлөгөөндөө хүрч чадаагүй. Хоёрдугаарт, ханшийн алдагдал байсан. Гуравдугаарт, санхүүжилтийн зардал бидний төлөвлөснөөс их байсантай холбоотойгоор 2024 онд төлөвлөгөөндөө хүрч чадаагүй байна. 2025 онд борлуулалтыг 6%-аар өсгөж 262 тэрбум, бүтээгдэхүүн дээр 4%-аар өсгөж 1,095,000 ширхэг бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн борлуулна гэсэн төлөвлөгөөтэй байгаа.

Энэ борлуулалтаа дотоод, гадаад, экспорт гэсэн 3 сегментээр хувааж танилцуулъя.

Дотоод борлуулалтын хувьд, 103%-ийн гүйцэтгэлтэй 163 тэрбумын борлуулалт хийсэн. Гол шалтгаан нь, брэндийн цогц шинэчлэлт, Төв дэлгүүрийн засвар болон шинэлэг бараа бүтээгдэхүүнийг зөв цагт нь нийлүүлсэнтэй холбоотой. Борлуулсан бүтээгдэхүүн нь 98%-ийн гүйцэтгэлтэй 659 мянган ширхэг бараа бүтээгдэхүүн борлуулсан байна. 2025 онд бид 2024 оны амжилтууд дээрээ үндэслэн шинэчлэлтүүд хийж шинэ бараа бүтээгдэхүүн нийлүүлснээр 20%-ийн өсөлтийг гаргаж 196 тэрбумын борлуулалт хийнэ. Бараа бүтээгдэхүүн дээрээ 27%-ийн өсөлт гаргаж 838 мянган ширхгийг борлуулахаар төлөвлөж байна. Тэр тусмаа борлуулалтын бүтцээр харвал, дотоодод жуулчдын тоо ихсэж байгаатай холбоотойгоор жуулчдын хувийг 35% байгааг 41% болгох төлөвлөгөөтэй байна.

Гадаад борлуулалтын хувьд бол манай салбарын болон манай компанийн ирээдүйн чухал сегмент байгаа. Гадаадын зах зээл дээр Монгол Улс чанартай, тогтвортой ноолуурыг зарж чаддаг системд оруулах нь манай компанийн 2025 болон дараагийн 5,10,20 жилийн хамгийн чухал ажил байна гэдэгт итгэлтэй байна. Үүний хүрээнд бид 2019 онуудаас эхлэн гадаадын олон улс, тивүүдэд охин компаниудаа байгуулан ажиллаж байгаа. Мөн 2019 оноос хойш олон жилийн турш маркетингийн хөрөнгө оруулалтуудыг хийсний үр дүнд 2024 оноос эхлэн бид үр шимээ хүртэж байгаа гэдгийг хэлэхэд таатай байна. 2024 онд бид гадаад борлуулалтын хувьд 93%-ийн гүйцэтгэлтэй 26 тэрбумын борлуулалт хийсэн. Маркетингийн зардал 89%-ийн гүйцэтгэлтэй 8 тэрбумыг зарцуулсан байна. Энэ нь өмнөх жилийн маркетингийн зардал болох 26 тэрбумаас эрс бууруулж 8 тэрбумд хүргэж, үр дүнтэй бөгөөд органик болон өмнөх жилүүдийн маркетингийн хөрөнгө оруулалтын үр шимийг хүртэж байгааг хэлэхэд таатай байна. Тэр тусмаа борлуулалтын бүтцээ тухайн зах зээлээр хувааж харвал, ЕХ, АНУ, БНХАУ, Их

Британи гэсэн улсуудад үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнээс онцолбол, АНУ 2024 онд борлуулалтын бүтцийн 27 %-ийг эзэлж байсан бол 2025 онд 30%-ийг эзлэхээр байгаа.

Гуравдугаарт, экспортын борлуулалт байна. Энэ нь бид өөрсдийн охин компаниар биш гаднын бизнесүүдэд дизайныг нь үйлдвэрлэж өгдөг онцлогтой. Экспорт борлуулалт 2024-2025 онд том зарчмын өөрчлөлт гаргаж байгаа. Энэ нь борлуулалтыг 64 %-аар бууруулж 21 тэрбумын борлуулалт хийнэ. Бараа бүтээгдэхүүнээ 57%-аар бууруулж 140 мянган ширхэгт хүргэнэ. Гол шалтгаан нь, манай экспортын борлуулалт нь гадаад ба дотоод борлуулалттай харьцахад маржин буюу нэмүү өртөг шингэсэн хувь нь илүү бага байдагтай холбоотойгоор экспортын борлуулалт ба тоо ширхгийг бууруулахаар бид төлөвлөж байгаа.

Үйлдвэрлэлийн хувьд, 2024 онд бид төлөвлөгөөгөө давуулан 109%-ийн гүйцэтгэлтэй буюу 1,005,000 ширхэг бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн. Нийт бараа материал үлдэгдлийн хувьд 123 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй. Үүн дээр онцолбол 2023-2024 онд бид бараа материалын үлдэгдлийг 143 тэрбумаас 123 тэрбумд хүргэж чадсан байна. 2025 онд нийт үйлдвэрлэлийн хувьд 956 мянган ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ, тэр тусмаа бүтээмж ихтэй ба байгальд ээлтэй 3D сүлжмэл бүтээгдэхүүнийг 79%-аар өсгөж 315 мянган ширхэгт хүргэх төлөвлөгөөтэй байна. Үүний үр дүнд бараа материалын үлдэгдэл 7%-аар буурч 114 тэрбумд хүрэх юм.

Инновац шингэсэн шинэ бараа бүтээгдэхүүн. 2023 онд эхлэн, 2024 онд үргэлжлүүлэн бид маш олон төрлийн ноолууран бүтээгдэхүүн буюу гутал, саравчтай малгай, цүнх, дотор дүүргэлттэй куртка, ноолууран дотортой савхин бээлий зэргийг дотоод болон гадаадын зах зээлд хүргэж чадсан.

Энэ нь 2025 оны манай үйл ажиллагааны зорилтод яаж нөлөөлж байгаа вэ гэдгийг танилцуулъя. 2025 онд бид дараах үндсэн 5 чиглэлд зорилтуудаа тавьж ажиллаж байна.

1. Чанартай, загварлаг бүтээгдэхүүн
2. Маркетинг ба борлуулалт
3. Дижитал шилжилт, процессын автоматжуулалт
4. Байгаль орчин, нийгэм, засаглал
5. Байгууллагын соёл ба ажилтны ур чадвар.

Энэ 5 үндсэн зорилгоос манай компанийн урт удаан хугацааны хамгийн гол зорилгууд нь 1 ба 2-р зорилтууд буюу хэрхэн чанартай, загварлаг бүтээгдэхүүн үйлдвэрлэж гадаад болон дотоодын зах зээл дээр зөв маркетингтайгаар борлуулах вэ гэдэг байгаа. Үүнийг дэмжих дижитал шилжилт, БОНЗ болон байгууллагын соёл, ажилтны ур чадвар зэргийг сайжруулах ажлуудыг байнгын системд оруулж соёлыг бүрдүүлнэ. Ингээд зорилт бүрийг дэлгэрэнгүй танилцуулъя.

Нэгдүгээрт, чанартай, загварлаг бүтээгдэхүүнийг борлуулах болон үйлдвэрлэх. Энэ зорилтын хүрээнд бид дараах ажлуудыг хийхээр төлөвлөж байна.

Дизайны инновац болон сайжруулалт

- Дэлхийд алдартай брэндэд ажилласан туршлагатай гадаад дизайнертай хамтын ажиллагаа

Шинэ бүтээгдэхүүн

- Инновац шингэсэн шинэ бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлж, загварын хөгжүүлэлт тасралтгүй хийх

Байгальд ээлтэй үйлдвэрлэл

- 3D буюу их бие оёдолгүй сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг 79%-аар нэмэгдүүлэх

Хоёрдугаарт, маркетинг ба борлуулалт. Энэ зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлууд бол:

Харилцагч төвтэй борлуулалтын стратеги

- Харилцагчийн удирдлагын систем /CRM/

- Үнэнч хэрэглэгчийн урамшууллын хөтөлбөр
- UI/UX сайжруулалт
- Дижитал маркетингийн үйл ажиллагааны цогц идэвхжүүлэлт

Full funnel аргачлалыг хэвшүүлэх

- Хэрэглэгчдийн эрэлтэд нийцсэн бүтээгдэхүүнийг, оновчтой байршилд, зөв маркетингтай, зохистой үнээр хүргэх
- Борлуулалт, үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүний нөөцийн уялдааг сайжруулах

Борлуулалтын сувгуудыг тэлэх

- Чингис хаан олон улсын нисэх буудал
- Дархан хот
- БНСУ-ын зах зээл
- Marketplace

Гуравдугаарт, дижитал шилжилт, процессын автоматжуулалт. Энэ зорилтын хүрээнд:

Бүтээмж сайжруулалт ба автоматжуулалт

- SAP систем
- Дамжлагын систем (Conveyor Belt)
- Үйлдвэр удирдлагын систем (MES)
- Microsoft Copilot Studio (AI)

Дөрөвдүгээрт, байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ). Энэ зорилтын хүрээнд:

БОНЗ-ын удирдлага

- Тогтвортой хөгжлийн стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, ханган нийлүүлэгч, харилцагч талуудтай хамтран ажиллах

Байгаль орчин

- Үйлдвэрийн хаягдал ус урьдчилан цэвэрлэх байгууламж шинэчлэн барьж, ашиглалтад оруулах

Нийгэм сайжруулалт ба автоматжуулалт

- Азийн Хөгжлийн Банктай хамтран "Бэлчээрийн шийдэл" төслийг 2 аймгийн 4 сумд хэрэгжүүлэх
- "Бизнес ба хүний эрхийн зарчим"-д тулгуурлан хүний эрхийн магадлан шинжилгээ хийх

Засаглал

- OEKO-TEX® STANDARD 100 стандартаар баталгаажсан бэлэн бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлж, органик коллекцийг шошгожуулах
- ISO 9001 - Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын стандартын магадлан аудитад 3 дахь жилдээ хамрагдах

Тавдугаарт, байгууллагын соёл ба ажилтны ур чадвар. Энэ зорилтын хүрээнд:

Ур чадвартай, сэтгэл ханамжтай ажилтныг бүрдүүлэх, тогтоон барих

- Ур чадвар, гүйцэтгэлд суурилсан цалингийн системийг хэрэгжүүлэх
- Ажилтнуудын сургалт хөгжил, ур чадварыг нэмэгдүүлж, сургалтын удирдлагын төслийг /LMS/ хэрэгжүүлэх

Ажлын байрны орчин нөхцөл сайжруулах:

- 6S хөтөлбөр
- Эрүүл, чанартай хоол
- Ажилтны хүүхдийн цэцэрлэг
- Хөхүүл ээжийн өрөө

Эдгээр ажлуудын үр дүнд бид нийт ажилтнууд, хэрэглэгч харилцагчид, малчин өрхүүд болон хувьцаа эзэмшигчдийнхээ үнэ цэнийг нэмэх ажлуудыг тасралтгүй хийснээр манай хамт олон дэлхийн хэмжээний брэнд болохын төлөө бид эрч хүч, итгэл үнэмшилтэйгээр ажиллаж буйгаа хэлэхэд таатай байна. Баярлалаа.

Та бүхэнд биднийг дэмжин ажилладагт маш их баярлалаа. Мөн анхаарал хандуулсанд баярлалаа.

Хөтлөгч: Гүйцэтгэх захиралдаа баярлалаа. Одоо 2024 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулна уу хэмээн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Хатагтай Сэлэнгийг дахин индэр дээр урьж байна.

4.2 Ногдол ашиг хуваарилахгүй тухай тогтоолыг танилцуулах *ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ танилцуулав.*

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ: Баярлалаа. 2024 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй болсон тухай шийдвэр хэрхэн гарсан тухай үндэслэлийг албан ёсоор танилцуулъя.

Говь ХК-ийн ТУЗ-ийн зүгээс баталсан Ногдол ашгийн журмын 2-р бүлэгт Ногдол ашгийн бодлогоо тодорхойлсон бөгөөд тус бодлогын 2-р зүйлийн 2.3, Компанийн тухай хуулийн 47-р зүйл, Компанийн дүрмийн 8-р зүйлийн 8.12-т заасан нөхцөл хангагдсан үед ногдол ашгийг хуваарилна гэж тодорхойлсон. Энэхүү нөхцөл нь ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх, мөн ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хуульд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх гэсэн үндсэн нөхцөлүүд байдаг. Мөн хуульд заасны дагуу санхүүгийн жил дууссанаас календарийн 50 хоногийн дотор ТУЗ-өөс ногдол ашгийн шийдвэрийг гаргах үүрэгтэй байдаг. Тус үүргийг харгалзан үзээд ТУЗ-ийн 2025 оны 2-р сарын 7-ны өдрийн №3 тоот тогтоолоор компанийн 2024 оны санхүүгийн үр дүнг хэлэлцээд компанийн ногдол ашгийн бодлогын 2.3-т заасан ногдол ашиг олгох нөхцөлийн хангаагүй буюу санхүүгийн зохистой харьцааг хангахгүй байгаа тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн байна.

Хөтлөгч: Баярлалаа, ТУЗ-өөс компанийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг Хурлын дарга Хатагтай Гэрэлмаа танилцуулна.

4.3 ТУЗ-өөс компанийн 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг танилцуулах

Хурлын дарга Д.Гэрэлмаа танилцуулав.

Хурлын дарга Д.Гэрэлмаа: Говь ХК-ийн санхүүгийн тайлан дээр KPMG хөндлөнгийн аудитын компани аудит хийсэн байгаа. Энэ талаар бас хурлын материалд дурдагдсан. ТУЗ нь компанийн 2024 оны санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны тайланг авч хэлэлцээд Говь ХК-ийн Гүйцэтгэх удирдлагын баг 2024 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан гэж дүгнэсэн.

Хөтлөгч: Баярлалаа. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Хуулийн хэлтсийн дарга Ноён Цасчихэр танилцуулна.

4.4 Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай танилцуулах

Хуулийн хэлтсийн дарга Ц.Цасчихэр танилцуулав.

Хуулийн хэлтсийн дарга Ц.Цасчихэр: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Говь ХК-ийн дүрэмд орох өөрчлөлтийг танилцуулъя. Та бүхэнд тараасан хурлын материалын 34 болон 35-р нүүрэнд харагдаж байна. Компанийн тухай хуульд орсон өөрчлөлттэй холбоотой 3 асуудал,

мөн зохицуулалтын 5 асуудал буюу нийт 8 асуудал байгаа. Одоогийн компанийн дүрэм нь 2022 онд шинэчлэгдсэн байгаа.

№	Одоогийн дүрмийн заалт	Шинэчилсэн заалт	Тайлбар
1	-	Арван нэг. Ахмадын сангийн тухай 11.1 Компани нь ажиллаж байсан ахмад настанд Ахмад настны тухай хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Ахмадын сан” байгуулан ажиллуулна. 11.2 Ахмадын сангийн мөнгөн хөрөнгийн хэмжээг гүйцэтгэх удирдлага нь 2 жилд нэг удаа Үйлдвэрчний эвлэл болон түүний дэргэдэх Ахмадын хороотой хэлэлцэн тогтооно.	Шинээр нэмж оруулав.
2	Арван нэг. Дүрмийн нэмэлт, өөрчлөлт. 11.1 Компанийн ТУЗ нь шаардлагатай тохиолдолд энэхүү дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах болон шинэчилсэн найруулгыг хийх бол энэ талаар санал боловсруулан хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж батлуулна. 11.2 Энэхүү дүрэм нь улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.	Арван хоёр. Дүрмийн нэмэлт, өөрчлөлт. 12.1 Компанийн ТУЗ нь шаардлагатай тохиолдолд энэхүү дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах болон шинэчилсэн найруулгыг хийх бол энэ талаар санал боловсруулан хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж батлуулна. 12.2 Энэхүү дүрэм нь улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.	Дугаарлалт өөрчлөгдөв.
3	5.1 Компани гаргасан энгийн хувьцааг заавал гаргаж ба үүнээс гадна давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг, хувьцаанд хамаарах үнэт цаасыг нээлттэй ба хаалттай хэлбэрээр гаргаж болно.	5.1 Компани энгийн хувьцааг заавал гаргах ба үүнээс гадна давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг, хувьцаанд хамаарах үнэт цаасыг нээлттэй ба хаалттай хэлбэрээр гаргаж болно.	Найруулга засав.
4	6.1.12 Хувьцаа—эзэмшигч өөрийн төлөөлөх этгээдийг бичгээр—олгосон итгэмжлэлийн үндсэн дээр хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцуулж болно. Төлөөлж оролцох этгээд энэ тухайгаа ТУЗ-д хурал эхлэхээс өмнө мэдэгдэнэ.	6.1.12 Хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хуралд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлэн оролцож болно. Төлөөлж оролцох этгээд энэ тухайгаа ТУЗ-д хурал эхлэхээс өмнө мэдэгдэнэ.	Өөрчлөлт оруулав.

5	6.2.8 ТУЗ-ийн ээлжит хурлыг 2-сард нэг удаа хуралдуулна. Шаардлагатай гэж үзвэл нэмэлт хуралдааныг хэдийд ч хийж болно. ТУЗ-ийн хурлын шийдвэр нь тогтоол байна. Тогтоолд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хөтлөх бөгөөд түүнд хуралд оролцсон бүх гишүүд өөрийн хэлсэн үг, гаргасан саналын үнэн зөвийг хянан гарын үсгээ зурна.	6.2.8 ТУЗ-ийн ээлжит хурлыг улиралд нэг удаа хуралдуулна. Шаардлагатай гэж үзвэл нэмэлт хуралдааныг хэдийд ч хийж болно. ТУЗ-ийн хурлын шийдвэр нь тогтоол байна. Тогтоолд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хөтлөх бөгөөд түүнд хуралд оролцсон бүх гишүүд өөрийн хэлсэн үг, гаргасан саналын үнэн зөвийг хянан гарын үсгээ зурна.	Өөрчлөлт оруулав.
6	7.1. ТУЗ-ийн Дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, компанийн Гүйцэтгэх захирал, дэд захирлууд, газрын захирлууд, хуулийн хэлтсийн дарга-зэрэг албан тушаалтныг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.	7.1. ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, компанийн Гүйцэтгэх захирал, дэд захирлууд, газрын захирлууд зэрэг албан тушаалтныг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.	Өөрчлөлт оруулав.
7	10.6 Татан буулгах комисс нь компанийг татан буулгах болон нэхэмжлэл гаргах хугацаа журмыг нийтэд болон зээлдүүлэгчид мэдээлнэ. Нэхэмжлэл гаргах хугацаа нь татан буулгах хугацаа нийтэд мэдээлснээс хойш 3-сар байна.	10.6 Татан буулгах комисс нь компанийг татан буулгах болон нэхэмжлэл гаргах хугацаа журмыг нийтэд болон зээлдүүлэгчид мэдээлнэ. Нэхэмжлэл гаргах хугацаа нь татан буулгах хугацааг нийтэд мэдээлснээс хойш хоёр сараас доошгүй, зургаан сараас дээшгүй байна.	Өөрчлөлт оруулав.
8	10.8 Нэхэмжлэл гаргах хугацаа дууссан өдрөөр тасалбар болгон компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, зээлдүүлэгчдийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагын дүнг тусгасан шаардлагын дүнг тусгасан татан буулгах түр балансыг гаргах бөгөөд уг балансыг хувьцаа эзэмшигчдийн хурал батална.	10.8 Нэхэмжлэл гаргах хугацаа дууссан өдрөөр тасалбар болгон компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, зээлдүүлэгчдийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагын дүнг тусгасан татан буулгах түр балансыг гаргах бөгөөд уг балансыг хувьцаа эзэмшигчдийн хурал батална.	Давхардсан хэсгийг засав.

Хөтлөгч: Баярлалаа. ТУЗ-ийн 2024 оны ажлын тайланг танилцуулна уу хэмээн Хурлын дарга Хатагтай Гэрэлмааг дахин индэр дээр урьж байна.

4.5 ТУЗ-ийн 2024 оны ажлын тайланг танилцуулах

Хурлын дарга Д.Гэрэлмаа танилцуулав.

Хурлын дарга Д.Гэрэлмаа: ТУЗ-ийн тайланг та бүхэнд танилцуулъя. Хурлын материалын 36-р хуудсанд дэлгэрэнгүй хэлбэрээрээ та бүхэнд хүргэгдсэн байгаа. ТУЗ-өөс 2024 онд хийж

гүйцэтгэсэн ажлын ерөнхий чиглэл, онцлох ажлууд, үнэлгээ зэрэг хүрээнд тайлангаа танилцуулъя.

ТУЗ-ийн ерөнхий бүтцийн талаар мэдээлэл хүргэе. ТУЗ нь 9 гишүүнтэй, ердийн 5 гишүүн, хараат бус 4 гишүүнтэйгээр ажилласан.

ТУЗ нь та бүхний эрхийг өөртөө шилжүүлж аваад компанийг хянах үүрэгтэйгээр, үндсэн үйл ажиллагаагаа ТУЗ-ийн хурлаар явуулдаг. Хурлын мэдээллийг та бүхэн дэлгэцээр харж байна. Төлөвлөгөөт 12 хурал, ээлжит бус 7 хурал, цахим санал хураалт 16 удаа явагдлаа. Өнгөрсөн жил бид нийт 114 асуудал авч хэлэлцээд 79 шийдвэр гаргаж, 41 санал зөвлөмж ба 50 үүрэг даалгаврыг гүйцэтгэх удирдлагын баг руу өгсөн байна. Энд зөвхөн тоо харагдаж байгаа боловч ард нь олон хүний цаг хөдөлмөр, нэлээдгүй олон асуудлын шийдлийг хамтдаа хайх, хэрэгжилтийг нь хангуулах болон хяналт тавих гэдэг чиг үүрэг бол хурлын үйл ажиллагаагаар өрнөдөг. Гишүүдийн оролцоо болон ирц нэлээд хангалттай байсан ба хараат бус гишүүдийн идэвх санаачилга өндөр байсныг хэлэхэд таатай байна.

Онцлох ажлуудаа танилцуулъя.

2024 он манай ТУЗ-ийн хувьд ихээхэн онцлог жил байлаа. Бид шинэ, залуу гүйцэтгэх удирдлагатай болсон. Нэг талдаа шинэлэг эрч хүчээр их цэнэглэгдэж байгаа, нөгөө талдаа шинэ, залуу захиралдаа зааж зөвлөх, чиглүүлэх ажлуудыг хийлээ. Хоёрдугаарт, онцлон хэлэх чухал ажил бол Тогтвортой хөгжлийн цогц бодлогыг баталж бүрэн тогтолцоогоороо хэрэгжиж эхэллээ. Тогтвортой хөгжлийн стратегийн бодлого, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бодлого, Хүний эрх, жендерийн бодлого, Нийгмийн хариуцлагын бодлогууд шинээр томъёологдоод холбогдох бодлогын хэрэгжүүлэх журмууд батлагдаад явж байгаа. Энэ бол бидний хувьд бол том амжилт гэж харж байна. Яагаад гэвэл ноолуур өөрөө бол байгалийн гаралтай бүтээгдэхүүн, мөн бэлчээрийн даац, малчид зэрэг олон хүчин зүйлд их нөлөөлдөг. Иймээс бид суурь үнэлгээнүүдийг хийсэн, цаашдаа хэрхэн яаж үүнийгээ тасралтгүй бууруулж явах вэ гэдэг чигээ гаргасан, үүнийхээ дагуу даацтай үйл ажиллагаагаа жигдрүүлээд аваад явах дүрэм журамтай, энэ асуудлыг хариуцах нэгжтэй, нийцлийг нь хариуцсан албатай буюу бүрэн дүүрэн тогтолцоогоор энэ асуудал руу орж ажиллаж байна. Мөн хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангах, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор манай ТУЗ болон ТУЗАА-ны зүгээс шинэ хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэн. Үүний хүрээнд:

- Говь ХК-аас гарч байгаа шинэ коллекцыг эхний ээлжид хувьцаа эзэмшигчдэдээ танилцуулах арга хэмжээ - 2 удаа
- Хувьцаа эзэмшигч нарын үйлдвэртэй танилцах аялал -2 удаа зохион байгуулав.
- Мөн ТУЗ-ийн хараат бус гишүүд болон удирдлагын төлөөлөл хувьцаа эзэмшигч Компанийн соёлын хүрээнд анхааран ажилласан буюу ТУЗ-ийн зүгээс компанийн хэмжээнд хэрэгжүүлж буй Компанийн соёлыг сайжруулахтай холбоотой арга хэмжээг дэмжин, шаардлагатай төсөв хөрөнгийг баталж, ажлын байрны тав тухтай орчныг бүрдүүлэх, цалинг үе шаттай нэмэгдүүлэх дээр анхаарч ажиллав.

ТУЗ-ийн тайлангийн төгсгөлийн хэсгийг танилцуулъя. Компанийн засаглалын үнэлгээ буюу Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн талаар мэдээлэл оруулсан байгаа. Санхүүгийн зохицуулах хорооноос хагас жил болон бүтэн жилээр кодексийн хэрэгжүүлж буй байдлыг үнэлж өгдөг. Сүүлийн хоёр үнэлгээгээр манай үр дүн бол 98.6% буюу өмнө жилийн эцсийн гүйцэтгэлээсээ 1.4%-аар өссөн. Энэ нь засаглал хэвийн буюу эрсдэлгүй ангилалд багтдаг. Мөн нэмээд сонирхуулж хэлэхэд энэ үзүүлэлтээрээ Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд багтдаг Монгол Улсын нээлттэй хувьцаат компаниуд дундаасаа бид засаглалын үнэлгээгээрээ тэргүүлж байна. Энэ нь манай ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн ажлын албаны ажилтнуудын хичээл зүтгэлийн үр дүнд гарч ирж буй гэж бодож байгаа. Ийм байгаагаар та бүхний эрх ашгийг дээдлэх, энэ зарчим Говь ХК-ийн ТУЗ, эрх бүхий албан тушаалтнуудад маш гүн гүнзгий суусан бөгөөд бид үүнийхээ төлөө хамтдаа ажиллах хангалттай суурьтай ба нэлээдгүй итгэл үнэмшилтэй, цаашдаа хамтын ажиллагаа болон хамтын удирдлагаа улам сайжруулж явах бат бэх суурьтай болсныг илтгэж буй болов уу гэж бодож байна. Баярлалаа.

Хөтлөгч: Баярлалаа. Эрсдэл аудитын хорооны 2024 оны үр дүнг танилцуулна уу хэмээн тус хорооны дарга, ТУЗ-ийн гишүүн Хатагтай Жаргалмаа таныг индэр дээр урья.

**4.5 ТУЗ-ийн ажлын тайланг танилцуулах /үргэлжлэл/
1.Эрсдэл аудитын хорооны ажлын тайланг танилцуулах**

*Эрсдэл аудитын хорооны дарга А.Жаргалмаа
танилцуулав.*

Эрсдэл аудитын хорооны дарга А.Жаргалмаа: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Манай хороо нь 2024 онд 3 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан.

Онцлох ажлуудыг дурдвал, хорооны ерөнхий хариуцдаг чиг үүргийн хүрээнд:

- Дотоод хяналт, комплайнс, эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах чиглэлээр дараах ажлуудыг хийсэн: Сонирхлын зерчилтэй болон холбоотой талуудтай хийгдсэн хэлцлийн гүйцэтгэлд улирал бүр, Дотоод аудитын хэлтсийн ажлын тайлантай улирал бүр, Эрсдэлийн удирдлагын багийн ажлын тайлантай хагас жил тутам, Комплайнсын удирдлага, үйл ажиллагааны тайлантай хагас жил тутам танилцаж удирдамжаар ханган ажиллав.
- “Комплайнсын бодлого”-ыг шинэчлэх төслийг хэлэлцэн ТУЗ-ийн хурлаар батлуулав.
- “Бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор боловсруулж буй Бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны төлөвлөгөөний явцтай танилцан санал зөвлөмжийг өгч ажиллав.
- Хараат бус аудиторын дүгнэлт зөвлөмжтэй танилцаж, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Мөн 2024 оны хөндлөнгийн аудиторын сонгон шалгаруулалтад хараат бус байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээг хийж, ТУЗ-ийн хурлаар сонгов.

Одоо 2024 онд холбоотой талуудтай хийсэн гүйлгээг танилцуулъя.

Говь ХК нь 2024 онд холбоотой талын санхүүжилтийн зардалд 7.4 тэрбум төгрөг төлсөн нь нийт санхүүжилтийн зардлын 25% эзэлж байна. Холбоотой талаас авсан санхүүжилтийн зардлын дундаж төгрөгийн хүү нь 13.2%, ам.долларын 7.7% байна. Холбоотой тал нь олгосон санхүүжилтэд санхүүгийн харьцаа болон барьцаа хөрөнгө шаарддаггүй онцлогтой байдаг.

2024 онд холбоотой талуудтай хийсэн гүйлгээ дундаас онцлон худалдан авалтыг танилцуулъя. Дотоодын нийт худалдан авалт бол 60.6 тэрбум байгаа үүний 55.3 тэрбум нь түүхий эдийн татан авалттай холбоотой, үлдсэн нь үйл ажиллагаатай холбоотой худалдан авалт байгаа. Говь ХК нь 2024 онд холбоотой талаас авсан худалдан авалтын дүн 2.9 тэрбум төгрөг буюу нийт худалдан авалтын 3.1%, дотоодын худалдан авалтын 4.9%-ийг эзэлж байна. Бүх холбоотой талын гүйлгээ нь Говь ХК-ийн Худалдан авалтын бодлого, холбогдох журмын дагуу үнийн харьцуулалт судалгааг хийн, сонгон шалгаруулалтын хороогоор орсны үндсэн дээр зах зээлийн үнээр хийгдсэн бөгөөд харилцан давуу байдлыг олгоогүй гэдгийг манай хорооны зүгээс мэдээлж байна.

Хөтлөгч: Жаргалмаа даргадаа баярлалаа. Одоо Нэр дэвшүүлэх хороо болон Цалин урамшууллын хорооны 2024 оны үр дүнг танилцуулна уу хэмээн тус хороодын дарга, ТУЗ-ийн гишүүн Ноён Хүрэлбаатарыг индэр дээр урья.

2. Нэр дэвшүүлэх хорооны ажлын тайланг танилцуулах

*Нэр дэвшүүлэх хорооны дарга Д.Хүрэлбаатар
танилцуулав.*

Нэр дэвшүүлэх хорооны дарга Д.Хүрэлбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны дарга нь Эрх бүхий албан тушаалтнууд буюу ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад Менежмент багийн удирдлагуудын залгамж халааны тогтвортой байдлыг хангах, тэдгээрийн ажил үүргийн тодорхойлолт, гэрээний нөхцөлийг

тодорхойлох, ажлын гүйцэтгэл, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч хяналт тавин, чиг удирдлагаар хангах үндсэн чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино. Мөн тус хороо нь ЭБАТ-уудтай холбоотой шүгэл үлээх системээр ирүүлсэн мэдээллийг шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг. Онцлох ажлуудыг дурдвал, хорооны ерөнхий хариуцдаг чиг үүргийн хүрээнд:

- Хурлын даргын хэлсэнчлэн Гүйцэтгэх захирал чөлөөлөгдөх хүсэлт өгсөнтэй холбоотой, шинээр томилох Гүйцэтгэх захирал дээр санал боловсруулан ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн томилж Менежментийн гэрээний нөхцөлийг шинэчлэн байгуулав.
- ТУЗ-ийн хараат бус гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгов. Сонгон шалгаруулалтыг нээлттэйгээр зарлаж, нийт 13 хүнээс журмын дагуу шаардлага хангасан 9 хүнийг авч хэлэлцэн ТУЗ-д хэрэгцээтэй байсан маркетинг чиглэлийн мэргэжилтэй, гадаадад ажилласан туршлагатай Б.Цээням гишүүнийг сонгон шалгаруулсан.
- ТУЗ-ийн болон ТУЗ-ийн гишүүний өөрийн үнэлгээний асуулгыг шинэчлэн баталж, 2024 оны үнэлгээг хийв.
- Шүгэл үлээх системээр ирсэн мэдээллийг тухай бүр шийдвэрлэн ажиллав.
- 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрсийг тодорхойлов.

3. Цалин урамшууллын хорооны ажлын тайланг танилцуулах

Цалин урамшууллын хорооны дарга

Д.Хүрэлбаатар танилцуулав.

Цалин урамшууллын хорооны дарга Д.Хүрэлбаатар: ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны зорилго нь ТУЗ-ийг Эрх бүхий албан тушаалтнууд буюу ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад Менежмент багийн удирдлагуудыг цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг тодорхойлох, Компанийн хэмжээнд баримтлах Цалин, урамшууллын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

Хорооны онцлох ажлууд:

- ТУЗ-ийн гишүүдийн цалин, хангамж, урамшууллын зарчмыг тодорхойлон, хараат бус гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хариуцлагыг үнэлэх зорилгоор хараат бус гишүүдийн цалингийн хэмжээг шинэчлэх санал боловсруулж төсвийн хамтаар 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар нээлттэй хэлэлцэн батлуулав.
- Байгууллагын соёлын судалгаа, ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн болон түүнийг сайжруулах чиглэлээр хийгдсэн ажлын үр дүнтэй танилцан санал зөвлөмжийг өгч ажиллав.
- Компанийн 2024 оны нийт цалин урамшууллын гүйцэтгэлд хяналт тавьж, 2025 оны төсвийг хэлэлцэн, ТУЗ-өөр батлуулав.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Хөтлөгч: Үргэлжлүүлэн ТУЗ-ийн 2025 оны цалингийн төсвийг танилцуулна.

4.6 ТУЗ-ийн 2025 оны цалингийн төсвийг

танилцуулах

Цалин урамшууллын хорооны дарга Д.Хүрэлбаатар

танилцуулав.

Цалин урамшууллын хорооны дарга Д.Хүрэлбаатар: Мөн манай Цалин урамшууллын хороо ТУЗ-ийн нээлттэй байдлын зарчмаар ТУЗ-ийн цалинг авч хэлэлцдэг. Өнгөрсөн онд төсвөө мөн батлуулсан. Энэ жилийн цалингийн төсөв төлөвлөгөөнд бол ямар нэгэн өөрчлөлт ороогүй. Өнгөрсөн оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулсан хэмжээгээрээ санал оруулж байна. Нийт зардлын төсвийг харвал 285.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан. Яагаад гэвэл өнгөрсөн оны эхээр биш журмын дагуу 4-р сард Хувьцаа эзэмшигчдийн хурлаар

батлуулж, тэр үеэс цалин өөрчлөгдсөн учраас 2025 оны төсөв тооны хувьд 328.9 сая буюу 14 хувиар өсөлт үзүүлсэн гэж харагдаж байна. Үүнээс өөрөөр бол энэ жилийн хувьд төсөвт өөрчлөлт ороогүй байна.

Одоогийн цалингийн бүтэц:

ТУЗ-ийн гишүүдийн цалингийн бүтэц		Цалин /төгрөг/
Тогтмол цалин	Үндсэн	1,400,000
	ТУЗ-ийн даргын нэмэгдэл	1,000,000
	Хорооны даргын нэмэгдэл	400,000
Оролцоонд үндэслэсэн цалин	Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд оролцсон тоогоор	650,000

Хурлын давтамж: /Нэг гишүүн жилд 9-11 хуралд оролцдог/

Хурлууд	Хурлын давтамж
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал	Жилд 1 удаа
ТУЗ-ийн ээлжит хурал	Улирал тутам буюу жилд 4 удаа
Эрсдэл, аудитын хорооны ээлжит хурал	Улирал тутам буюу жилд 4 удаа
Нэр дэвшүүлэх хорооны ээлжит хурал	Хагас жил тутам буюу жилд 2 удаа
Цалин, урамшууллын хорооны ээлжит хурал	Хагас жил тутам буюу жилд 2 удаа

ТУЗ-ийн гишүүдийн цалингийн төсөв:

Агуулга	2024 он			2025 он		
	Төсөв	Гүйцэтгэл	Гүйцэтгэл %	Төсөв*	2025Т/2024Т өөрчлөлт	Өөрчлөлт %
Тогтмол цалин	211,200,000	213,533,333	101%	237,200,000	26,000,000	12%
Оролцооны цалин	50,700,000	44,200,000	87%	59,150,000	8,450,000	17%
НДШ	30,118,500	27,371,050	91%	32,598,500	2,480,000	8%
Нийт цалин	292,018,500	285,104,383	98%	328,948,500	36,930,000	13%

Хөтлөгч: Хороодын дарга нартаа баярлалаа, үүний дараа ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Хатагтай Сэлэнгэ та бүхэнд танилцуулах болно.

4.7 ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулгыг танилцуулах

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ

танилцуулав.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ: Хэлэлцэх асуудлын сүүлийн асуудал буюу ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулъя. Говь ХК-ийн дүрмийн 6.2.3-д ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 3 жил байхаар заасан. Энэ жилийн хувьд Компанийн тухай хуулийн дагуу Говь ХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Таван Богд Холдингс ХХК-аас 2025 оны 2-р сарын 28-ны өдөр ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчид санал оруулах тухай албан хүсэлт ирүүлсэн. Тус хүсэлтийг Нэр дэвшүүлэх хорооны хурлаар хэлэлцэн 2025 оны 3-р сарын 17-ны өдрийн №02 тоот тогтоолоор 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ТУЗ-ийн бүрэлдэхүүнд нэр дэвшигчдийг тодорхойлсон. Ингээд хараат бус гишүүнд 3 хүн, ердийн гишүүнд 6 хүн нэр дэвшиж байна.

/Хувьцаа эзэмшигчдийн хурлын материалын 48-р хуудаснаас 52-р хуудас дахь нэр дэвшигчдийн танилцуулгыг танилцуулав./

Хөтлөгч: Баярлалаа. Одоо хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариултын хэсэгт шилжье. Асуулт хариултын хэсэг 20 минутын хугацаанд үргэлжилнэ. Хүн тус бүр 2 минутад багтаан асуултаа асуухыг анхаарна уу. Та асуулт асуух хүсэлтэй бол гараа өргөвөл зааланд байгаа манай ажилтнууд танд микрофон өгөх болно.

5. АСУУЛТ ХАРИУЛТ

/Нийт 20 минут/

АСУУЛТ 1.

Хувьцаа эзэмшигч 1: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Хэдэн асуулт байна.

1. ТУЗ-д нэр дэвшигчдийн материалыг бүтнээр нь үзмээр байна. Яагаад хараат бус гишүүнээр нэр дэвшиж байгаа хүмүүс нь одоо ТУЗ-д байгаа 3 хүн байгаа вэ? Энэ 3 хүн ямар ёс зүйн үүднээс нэр дэвшиж байгаа вэ? Өөр материал ирүүлсэн хүмүүс байгаа байх, тэрийг хармаар байна. Цээням гишүүн өмнө нь хараат бус гишүүн байсан боловч одоо яагаад ердийн гишүүн болоод нэр дэвшээд ороод ирсэн бэ?
2. 2025 оны бизнес төлөвлөгөөг ерөөсөө ярьсангүй. 1-р улирлын биелэлт ямар байгаа вэ? Энэ дотор орлого ба зарлагын харьцаа ямар хувиар биелсэн талаар ямар ч тоо хэлсэнгүй.
3. ТУЗ-ийн хараат бус гишүүд өмнөх жилүүдэд яагаад олигтой ажилласангүй вэ? Энэ компанийн алдагдал, өр шир нь замбараагаа алдлаа. Ийм байхад яагаад ахиад нэр дэвшиж байгаа вэ? Ямар нэгэн ёс зүйн хариуцлага байхгүй юу?
4. Хурлын хэвлэмэл материал нь одоо энэ тайлан дээр танилцуулж байгаа мэдээллээс өөр байна. Зарим үг үсэг зөрөөд байна. Энэ нь хууль зөрчиж байгаа юм биш үү? Энэ хурлыг хүчин төгөлдөр биш гэж үзэх нөхцөл бүрдэж байгаа юу? гэсэн асуултуудыг асуумаар байна.

ХАРИУЛТ:

Хурлын дарга Д.Гэрэлмаа: Хэд хэдэн асуулт ирлээ. Эхний асуулт нь, ТУЗ-ийн хараат бус гишүүнд өөр нэр дэвшигч байгаагүй юу гэдэг асуулт гарч ирж байна, үүнд ТУЗ-ийн зүгээс хариулна. 2-р асуулт нь, 2025 оны төлөвлөгөөний талаар манай Гүйцэтгэх захирлын танилцуулгад сая гарсан байгаа, сонирхож байгаа асуулт байгаа юу гэдэг дээр та тодруулга өгөөч. Үүнд манай Гүйцэтгэх удирдлагын баг хариулна. 3-р асуулт нь, Цээням гишүүний талаар байсан. Хараат бус гишүүн сонгон шалгаруулах журмаар сонгосон талаар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариулна. 4-р асуулт нь, хурлын материал ба дэлгэц дээр гарсан мэдээллээс зөрсөн гэдэг дээр та тодорхой хэлж өгнө үү, үүн дээр нь тайлбар өгөх хүсэлтэй байна. Таны асуултыг зөв ойлгосон байна уу? Тийм бол эхний асуултдаа хариулъя.

ТУЗ-ийн хараат бус гишүүдийн нэр дэвших процессын хувьд Компанийн тухай хууль болон холбогдох журмаар ТУЗ-ийн гишүүд 3 жилийн хугацаатай сонгогдож байгаа. Өнгөрсөн жил бүрэн бүрэлдэхүүнээрээ сонгогдсон. Энэ жил нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдээс санал ирж, Таван Богд Холдингс ХХК-ийн удирдлагаас нэг хүн орж ирэхээр болсон ба ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ажиллаж байсан Б.Цээням нь Таван Богд Холдингс ХХК-аас ажлын санал хүлээн авч, ажиллах болсон. Ийм нөхцөл үүсэж хугацаагаараа бол 3 жилийн хугацаатай ажиллах байсан ТУЗ-ийн бүрэлдэхүүн энэ жил ахиж сонгогдох болсон байгаа.

Тайлан мэдээлэлтэй холбоотой зүйлс дээр зөрүү байгаа мэдээлэл нь яг юу байгаа вэ? Үүн дээр тодруулга өгнө үү.

Хувьцаа эзэмшигч 1: Одоогийн байдлаар Баатарсайхан захирал ТУЗ-ийн дарга болсон боловч хэвлэсэн тайлан материал дээр ТУЗ-ийн дарга Гэрэлмаа гэж бичсэн байна гэх мэтчилэн наад захын алдаанууд байна. Хэвлэхээсээ өмнө сайн харж байгаарай. Мөн бизнес төлөвлөгөө дээр гол нь тоо чухал байна, үг үсэг бол хамаагүй. Ямар зорилго тавьсан, өр авлага ямар тооноос яаж өөрчлөгдсөн, мөн хэзээ ашигтай ажиллана гэж харж байгаа гэх мэтчилэн тоон мэдээлэл хармаар байна. Үг үсэг яримааргүй байна.

ХАРИУЛТ:

Хурлын дарга Д.Гэрэлмаа: Баярлалаа. Асуултыг ойлголоо. Энэ хэвлэмэл материал бол 2024 оны тайлан байгаа. 2024 оны туршид миний бие Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар ажиллаж байсан тул тайлан дээр ингэж орж хэвлэгдсэн байгаа. Үүн дээр зөрчилтэй зүйл байхгүй гэж бодож байна. 2025 онд буюу энэ Хувьцаа эзэмшигчдийн хурлын дараагаар ТУЗ-ийн гишүүд шинэ бүрэлдэхүүнээрээ ТУЗ-ийн даргаа сонгох байгаа. Одоогийн байдлаар ТУЗ-ийн даргаар Баатарсайхан ажиллаж байна. Дараагийн асуулт дээр манай Гүйцэтгэх удирдлагын багаас хариулна.

Санхүү хариуцсан захирал Б.Хангалан: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Намайг Хангалан гэдэг. Санхүү хариуцсан захирлаар 2025 оны 2 сараас томилогдон ажиллаж байна. 2025 оны хувьд бид 262 тэрбумын борлуулалтын төлөвлөгөөтэй ажиллаж байна, энэ нь өнгөрсөн оны 247 тэрбумын борлуулалттай харьцуулахад 6 хувийн өсөлт байгаа. Та бүхэн дэлгэцээс харах боломжтой. Дотоод борлуулалт дээр бид 20 хувийн өсөлт, гадаад борлуулалт дээр 73 хувийн өсөлтийг төлөвлөж байна. Экспортын борлуулалтын хувьд бид ашигт ажиллагаанаас шалтгаалан бодлогын хувьд бууруулан 64 хувиар бууруулж 21 тэрбумын борлуулалт хийнэ гэсэн төлөвлөгөөтэй ажиллаж байна. Цэвэр ашгийн хувьд, манай хамт олон бүгд ашигтай ажиллахыг зорьж ажиллаж байгаа. Эхний 3 сарын гүйцэтгэлийг танилцуулбал, 1-р улирлын гүйцэтгэл 38.9 тэрбумын борлуулалт төлөвлөснөөс 38.3 тэрбум буюу 98%-ийн гүйцэтгэлтэй явж байна. Энэ үзүүлэлт нь 2024 оны 1-р улиралтай харьцуулахад 8%-ийн өсөлт гаргасан борлуулалт хийсэн гүйцэтгэлтэй байна.

АСУУЛТ 2.

Хувьцаа эзэмшигч 2: Тайлантай холбоотой нэг зүйл асууя. КОВИД-ын үед 2020-2022 онуудад Говь ХК их ашигтай ажилласан байна. Хаанаас, яаж ийм их ашиг олж ажилласан бэ? Өмнөх жилээс 66%-аар буурсан гэсэн байх юм. Юунаас болоод буурсан бэ?

ХАРИУЛТ:

Санхүү хариуцсан захирал Б.Хангалан: Энэ дээр ахиад би хариулт өгье. Та хэвлэмэл материалын 9-р хуудасны графикийг хэлж байна. Ногоон зураасаар бид алдагдлыг харуулж байгаа. 2020 оноос Говь ХК нь алдагдалтай ажилласан байгаа. Үнийн дүнгээрээ 2020 онд 46 тэрбумын алдагдалтай гэж бичсэн байгаа, 4-ийн тоо нь график дээрээ гарсан байна, та ахиад тодруулаад хараарай. 2021 онд 37.9 тэрбумын алдагдал, 2022 онд 7.0 тэрбумын алдагдал, 2023 онд 6.8 тэрбумын алдагдал, 2024 онд 3.7 тэрбумын алдагдал гээд та ногоон зураасыг хараарай.

АСУУЛТ 3.

Хувьцаа эзэмшигч 3: Сайн байцгаана уу? Хувьцаа эзэмшигч Цэдэндамбаа байна. Хэдэн асуулт байна.

1. 2024 онд мөн нэг гол өөрчлөлт гарсан нь нөлөө бүхий хувьцаа эзэмшигчтэй холбоотой байна. Савада гэж хүн хасагдаад, Таван Богд Холдингс ХХК-ийн хувь эзэмшил 87 хувь болсон юм байна. Энэ гаднын хувьцаа эзэмшигч яагаад гараад явсан бэ? Өөрөө хүсэлтээ тавьсан уу, яасан бэ гэдгийг асууя. Мөн үүнийг дагалдаад өнгөрсөн жил зарим хувьцаа эзэмшигчдээс хувьцаагаа эргүүлж худалдаж авах болсон. Үүнийг би яаж харж байгаа вэ гэхээр Говь ХК нь ХХК болох зам руугаа явж байна уу? Үүнд ТУЗ-ийн зүгээс тодорхой хариулна уу. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Хулан мөн өөрөө байна.
2. Мөн хувьцааны төвлөрлөө багасгах арга хэмжээ авах уу? 87 хувь гэдэг их байна. Бага хувьцаа эзэмшигчид 12 хувь гэдэг дэндүү бага байна. Цаашдаа нэмж хувьцаа гаргах бодлого баримталж байгаа юу? Энэ нь цаашлаад бас компанийн өртэй холбогдож байгаа, компани маш их зардалтай ажиллаж байгаа. Нэмэлт хувьцаа гаргаад санхүүжилт босгоод урт хугацааны өр төлбөрөө барагдуулбал ашигтай ажиллах боломж байгаа. Ялангуяа КОВИД-оос хойш 5 жил ямар ч ногдол ашиг тараагаагүй.

Үргэлжлээд алдагдалтай яваад байх юм уу? Жижиг хувьцаа эзэмшигч нарын эрхийн асуудал томоор хөндөгдөж байна гэж асуумаар байна.

3. Хувьцааны төвлөрлөө багасгах ямар бодлого баримталж байна вэ? Урт хугацаандаа хувь эзэмшлээ багасгах уу, нэмэлт хувьцаа гаргах уу гэдэгтэй холбогдож байгааг бас хэллээ.
4. Гүйцэтгэх захирлын тайланг сонслоо. Эрч хүчтэй, залуу хүн шинэлгээр сайн ажиллах гэж оролдож бас хичээж байгаа юм байна гэж ойлголоо. Тодорхойгүй зүйлс гэхдээ бас байна. Говь ХК-ийн зах зээлд өрсөлдөх чадвар хэр байгаа вэ? Зах зээл дэх хувь эзэмшилтэй холбоотой асуудлууд ярьсангүй. Миний харж байгаагаар Ханбогд зэрэг өрсөлдөгч компаниуд нэлээд эрч хүчтэй сайн ажиллаад зах зээл дэх хувь эзэмшлээ нэмэгдүүлж байгаа. Яагаад Говь ХК ийм туршлагатай, чадамжтай, хүний нөөцтэй мөртөө ингэж алдагдалтай яваад байгаа вэ? Үүн дээр ямар өөрчлөлт хийж ямар дүгнэлт гаргаж байгаа вэ? гэдгийг тодруулмаар байна.
5. Ахиад Гүйцэтгэх захирлаас тодруулах зүйл бол Говь ХК-д түүхий эд бэлтгэлийн тогтолцоо байдаг уу? Бусад компаниуд орон нутаг дахь том хоршоодтой гэрээлдэг. Ялангуяа Италийн өрсөлдөгч нар гол ноолуурын бүс нутгуудтай гэрээ байгуулсан, түүхий эд нь ачигдаад гараад явж байна. Энэ дээр хэр бодлоготой ажиллаж байна? Ер нь түүхий эдээ цаашид яаж тогтвортой байлгах вэ гэдгийг тодруулж асуумаар байна.
6. Бас ТУЗ-ийн зардлын төсвийг нэмсэнтэй холбоотой асуумаар байна. Яагаад энэ компани өөрөө ашиггүй ажиллаж байхад зардал өсөөд байгаа юм бэ? Борлуулалтыг харвал КОВИД-ын үеэс борлуулалт хамаагүй өссөн харагдаж байна. КОВИД-оос өмнө ногдол ашиг тарааж болоод байсан. Одоо тэр түвшиндээ хүрсэн мөртөө ашиггүй ажиллаж байна гэхээр агуулгаар нь аваад үзвэл маш муу ажиллаж байна гэдэг дүгнэлтэд хүрэхээр байна. Үүн дээр холбогдох хүмүүс ямар байр суурьтай байгаа вэ? Энэ хэдэн асуултад хариулт авъя. Баярлалаа.

ХАРИУЛТ:

Хурлын дарга Д.Гэрэлмаа: Алдагдалтай холбоотой ямар дүн шинжилгээ хийж ямар дүгнэлтэд хүрч байгаа вэ гэдэг асуулт дээр миний бие хариулъя. 2019 онд Говь ХК нь онлайн буюу е-commerce руу орсон. Гадаадад буюу олон улсын зах зээлд бараа бүтээгдэхүүнээ борлуулах үйл ажиллагааг эхлүүлсэн. Аль аль талдаа цоо шинэ туршлага болж байгаа. Маш их хэмжээний хөрөнгө оруулалтууд хийгдсэн. Нөгөө талдаа, олон улсын зах зээлд үйл ажиллагаа явуулахад ганцхан өөрийн бүтээгдэхүүнийг сурталчлахаас гадна Монгол Улсаа, бүтээгдэхүүнийхээ гарал үүсэл зэргийг танигдуулахаар тулд борлуулалт явдаг тавцангууд дээр маш өргөн дэлгэр бөгөөд том хэмжээний маркетингуудыг өндөр зардалтайгаар хийх шаардлагатай болсон. Үүн рүү 2019 оноос хойш тасралтгүй өндөр хэмжээний маркетингийн зардалтай ажиллаж байгаад өнгөрсөн жилээс боломжит бүх зардлыг танах арга хэмжээ авч зардал өөрөө буурсан. Гэхдээ онлайн худалдааны нэг онцлог байдаг. Органикаар өөрөө тоолуургүй танигдалт яваад маркетингийн зардлыг тодорхой түвшинд барих замаар борлуулалт органикаар явж байгаа. Нэмж үүн рүүгээ ахиж өндөр хэмжээний зардал гаргах боломж алга. Гэхдээ одоо бол мэдээж алдагдалтай ажиллаж буйг хүлээн зөвшөөрч байгаа шалтгаан бол миний туршлагаас харахад КОВИД-ын нөлөө нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд маш хүнд цочрол оруулдаг юм байна. Нэг ийм хөдөлгөөнд орчихоор эргээд үүнийг тогтворжуулахад нэлээд даацтай бас багагүй хугацаа шаардсан ажил болдог юм байна гэдэг ажиглалтыг хувь хүнийхээ зүгээс хийж байгаа. Мэдээж байдаг чадлаараа алдагдалгүй ажиллахыг зорин хичээн ажилласан. Гэхдээ харамсалтай нь бидний хичээл зүтгэл бол зорьсондоо хүрч чадаагүй байгааг та бүхэн мэдэж байгаа. Бас ойлгосон байгаа гэж найдаж байна. Савада сантай холбоотой асуултад хариулт өгөхийг ердийн гишүүн Хулан захирлаас хүсье.

ТУЗ-ийн гишүүн Д.Хулан: Сайн байцгаана уу, Хиде Интер гэдэг компани анх Говь ХК хувьчлагдахад манай түнш болж орж ирж байсан. Савада Хидео гэдэг Япон хүн манай хамтрагч байсан. Тэр хүн одоо нас өндөр болоод өөрөө тэтгэвэрт гармаар байна, ажлаа

өгмөөр байна гээд Монголын хөрөнгийн бирж дээр арилжаалагддаг тул эхлээд үнэт цаасны компанид хандсан байсан. Багцаар нь худалдаална гэсэн хүсэлтэй байсан тул нийтдээ нэлээн том дүнтэй учраас өөр өрсөлдөгч гарч ирээгүй. Тиймээс бид олон жил түншилсэн түншийнхээ хүсэлтийг биелүүлэх үүднээс авахаас өөр аргагүй болсон. Хаалттай компани болох уу гэдэг асуудал дээр бид бол одоохондоо шийдвэр гаргаагүй. Аль болохоор арилжаалагддаг, нээлттэй компани болохыг хүсэж байгаа. Хамгийн гол нь жижиг хувьцаа эзэмшигчдэд өгөөжөө өгөхийн тулд нэн тэргүүнд, маш яаралтай ашигтай ажиллуулъя гэж бодож байгаа. Тэр утгаараа бид маш олон төрлийн дүн шинжилгээнүүд хийгээд ашгийн маржин бага тул бөөний экспортын борлуулалтаасаа татгалзаж байгаа. Харин дотоод ба онлайн худалдаагаа эрчимжүүлж гэсэн стратегийн шийдвэр гаргаад гадаадад сурч, гадаадын хэрэглэгчдийг илүү сайн таньж мэдсэн Б.Амарсайханыг Гүйцэтгэх захирлаар өнгөрсөн оны 3 сарын 1-ээс томилсон. Мөн Таван богд группийн зүгээс бид бүхий л дэмжлэгийг үзүүлээд явж байгаа. Тэгэхээр бид хамгийн түрүүнд Говь ХК-ийг энэ жилдээ яаж ийж байгаад ашигтай болгоно. Сууриа зөв тавиад явбал цаашид ашигтай ажиллаад та бүхэндээ бол өгөөж, ногдол ашгаа өгнө гэж бодож байгаа.

Хурлын дарга Д.Гэрэлмаа: Алдагдалтай ажиллаж байхад ТУЗ яагаад зардлаа нэмээд байгаа вэ гэдэг асуултад хариулъя. Бид зардал нэмэгдүүлэх чиглэлийн төсвийг оруулаагүй байгаа. Өмнө жилийн гүйцэтгэлээр энэ жилийн төсвөө оруулж байгаа гэдгийг анхааралдаа аваарай. Дараагийн асуултад Гүйцэтгэх захирал хариулна.

Гүйцэтгэх захирал Б.Амарсайхан: Нэгдүгээрт, дотоодын зах зээл ба гадаад дахь үйл ажиллагаатай холбоотой асуултад хариулъя. Дотоодын зах зээл дээр бид дотоод борлуулалтыг дэмжих зорилгоо Rebranding болон Төв дэлгүүрийн засвар шинэчлэлт ба шинэлэг бараа бүтээгдэхүүнүүдийг нийлүүлж байгаа. 2024 оны байдлаар бид дотоодын зах зээлийн 50-60 буюу дунджаар 55 хувийг эзэлж байгаа гэдэг мэдээлэлтэй байгаа. Үүн дээр бид ирээдүйд юуг анхаарч хийх вэ гэвэл бараа бүтээгдэхүүний чанар болон загвар дизайн дээр анхаарна, бас байнгын маркетингийн үйл ажиллагаагаа сайжруулна. Мөн дэлгүүрүүдийнхээ үйлчилгээг сайжруулна гэдэг зарчмын дагуу ажиллаж, борлуулалт болон эзлэх хувиа өсгөнө гэдэг төлөвлөгөөтэй байгаа.

Хоёрдугаарт, борлуулалт болон ашигтай холбоотой. Ашигтай холбоотойгоор, дотоодын зах зээлд сая дурдсан хөрөнгө оруулалтуудыг хийнэ. Мөн илүү маржин багатай үйл ажиллагаагаа багасгаж, илүү өөрсдийн охин компаниараа дамжуулах буюу EX, АНУ, БНХАУ, Их Британи болон энэ жилээс эхлэн БНСУ-ын зах зээл рүү орж илүү өндөр маржинтай борлуулалтыг хийж ашигтай ажиллана гэсэн зорилготой байгаа.

Түүхий эдтэй холбоотой хариулъя. Өмнөх жилүүдэд болон энэ жилд үргэлжлүүлэн бид голдуу өөрсдийн үйл ажиллагааг дэмжих болон эцсийн бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх зорилтот хэмжээгээр түүхий эд татан авалтыг хийдэг. Бид самнасан ноолуур болон түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүн гадаад руу гаргах зорилготой ажилласан. Гол шалтгаан нь энэ нь хамгийн бага маржинтай борлуулалт байдаг. Тэгэхээр эцсийн дүндээ, орлого болон ашгаа нэмэгдүүлэхийн тулд хамгийн өндөр маржинтай гадаадын зах зээл рүү эцсийн бараа бүтээгдэхүүнээ Говь брэнд болон Монголын Улсынхаа нэр хүндийг таниулан ажиллаж байгаа.

Хөтлөгч: Та бүхэндээ баярлалаа. Асуулт хариултын хэсэг энд хүрээд өндөрлөж байна. Танд нэмэлт асуулт болон санал хүсэлт байвал таныг бүртгүүлэхэд өгсөн жижиг санал хүсэлтийн хуудсанд бичээд **САНАЛ ХҮСЭЛТИЙН ХАЙРЦАГТ** хийнэ үү. Санал хүсэлтийн хайрцаг нь танхимын зүүн гар талд байрлаж байна.

Одоо санал өгөх зааварчилгааг танилцуулна уу хэмээн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Хатагтай Сэлэнгийг дахин индэр дээр урьж байна.

7. САНАЛ ХУРААЛТ

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ санал өгөх зааврыг танилцуулан, санал хураалтыг албан ёсоор нээж нийт санал хураалт нийт 10 минут үргэлжлэв.

Хөтлөгч: Саналын хуудсаар санал авч эхэллээ. Та бүхэн танилцуулсан зааврын дагуу саналын хуудсыг бөглөн танхимын баруун гар талд байрлах Тооллогын комиссын ширээн дээрх шар өнгөтэй САНАЛЫН ХАЙРЦАГТ хийнэ үү. Хэрэв саналын хуудас бөглөхөд ойлгомжгүй зүйл гарвал та зааланд байгаа манай ажилтнуудаас болон Тооллогын комиссоос асууна уу.

7. САНАЛ ХУРААЛТЫН ДҮНГ НЭГТГЭХ

Тооллогын комисс саналын хайрцгийг задлан, санал хураалтын дүнг нэгтгэв. Нийт 20 минут үргэлжлэв.

Хөтлөгч: Саналыг нэгтгэж дууссан тул Санал хураалтын дүнг танилцуулж, тогтоолыг батлуулна уу хэмээн Тооллогын комиссын дарга Хатагтай Сайнзулыг та бүхний өмнө урьж байна.

8. САНАЛ ХУРААЛТЫН ДҮНГ ТАНИЛЦУУЛАХ

Тооллогын комиссын дарга Н.Сайнзул танилцуулав.

Монгол улсын Компанийн тухай хуулийн 67.3, Говь ХК-ийн дүрмийн 6.1.10-6.1.16 заалтыг удирдлага болгон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал хураалтын дүнг нэгтгэн тоолсныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Нийт **89.06** хувийн саналын эрхтэй **694,791,015** ширхэг хувьцааны **654** ширхэг саналын хуудас хураасныг тооцсугай.
2. 2025 оны 04-р сарын 25-ны өдөр санал хураах хайрцгаар **87.35** хувийн саналын эрхтэй **681,449,159** ширхэг хувьцааны **91** ширхэг саналын хуудас хураасныг дурдсугай.
3. Урьдчилж ирүүлсэн саналын хуудасны хувьд, цахим хаягаар дамжуулж **0.00** хувийн саналын эрхтэй **200** ширхэг хувьцааны **1** ширхэг саналын хуудас, компанийн байранд **1.71** хувийн саналын эрхтэй **13,341,656** ширхэг хувьцааны **562** ширхэг саналын хуудас тус тус урьдчилж ирүүлснийг дурдсугай.
4. Нийт саналын хуудаснаас **0.01** хувийн саналын эрхтэй **116,314** ширхэг хувьцааны **96** ширхэг саналын хуудас хүчингүй болсныг дурдсугай.
5. Говь ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг хуралд оролцогчдын саналын эрхийн олонхоор буюу **99.99** хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.
6. Компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай асуудлыг хуралд оролцогчдын саналын эрхийн олонхоор буюу **99.99** хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.
7. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны цалингийн төсвийг батлах тухай асуудлыг хуралд оролцогчдын саналын эрхийн олонхоор буюу **99.99** хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.
8. Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус болон ердийн гишүүдийг сонгох асуудлаар хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналыг кумулятив аргаар тоолж, хамгийн олон санал авсан 9 гишүүдийг сонгон томилсныг мэдэгдсүгэй.

Хөтлөгч: Баярлалаа. Хурлаас гарах тогтоолын төсөлд санал хураалтын дүнг тусган танилцуулж, батлуулна уу хэмээн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Хатагтай Сэлэнгийг индэр дээр урья.

9. ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫГ ТАНИЛЦУУЛАХ

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ танилцуулав.

Тооллогын комиссын санал хураалтын үр дүнд үндэслэн хурлаас гарах дараах 4 тогтоолын төслийг танилцуулав.

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай
2. Компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай
3. ТУЗ-ийн 2025 оны цалингийн төсвийг батлах тухай
4. ТУЗ-ийн гишүүдийг сонгон томилох тухай

Хөтлөгч: Баярлалаа. Ийнхүү Говь Хувьцаат Компанийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хааж үг хэлнэ үү хэмээн Хурлын дарга Хатагтай Гэрэлмааг индэр дээр урьж байна.

ХУРЛЫН ХААЛТ

Хурлын дарга Д.Гэрэлмаа: Баярлалаа. Хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигч нартаа дахин талархал илэрхийлье. Бид бүгдийн жил бүр тайлангаа тавьдаг ээлжит хурал амжилттай болж өнгөрлөө. Идэвхтэй оролцсон болон маш олон асуулт тавьсан хувьцаа эзэмшигч нартаа баярлалаа. Үүгээр Хувьцаа эзэмшигчдийн хурал хаасныг мэдэгдье. Та бүхэнд сайн сайхныг хүсье.

Хөтлөгч: Өнөөдрийн хуралдаанд идэвхтэй оролцож, компанийнхаа үйл ажиллагаа, засаглал, ирээдүйн хөгжилд үнэтэй санал бодлоо хуваалцсан та бүхэндээ Гүйцэтгэх удирдлагын баг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлье.

Компанийн үнэт хувьцаа эзэмшигч та бүхний итгэлцэл, хяналт, дэмжлэг нь бидний хөгжил дэвшлийн суурь болж ирсэн бөгөөд цаашид ч үргэлжлрэх болно гэдэгт бид бүрэн итгэлтэй байна. Ийнхүү "Говь" ХК-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал өндөрлөж буйг албан ёсоор мэдэгдье.

Хүрэлцэн ирсэн та бүхэндээ баярлалаа.

Хурал 16 цаг 00 минутад өндөрлөв.

Хурлын даргалагч:

Хурлын дарга



Д.ГЭРЭЛМАА

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Засаглалын мэргэжилтэн



Г.ДЭМЧИГСЭЛМАА

